



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 8/309


Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 24 дүгээр  
цэцэрлэгийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бусхөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4 227 250 /Дөрвөн сая хоёр зуун хорин долоон мянга хоёр зуун тавин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 24 дүгээр цэцэрлэг /Д:Энхцэцэг/-т зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 24 дүгээр цэцэрлэг /Д:Энхцэцэг/-т үүрэг болгосугай.
3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 06 сарын  
 06 өдрийн 01309 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 24 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Хашаа /төмөр/	1/1/1960	59	м2	228.5	18,500	4,227,250.0	4,227,250.0	0	ашиглах боломжгүй	татах
Нийт дүн							4,227,250.0				
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн							4,227,250.0				